

БУУДАЙН ҮРИЙН МӨӨГӨНЦӨРИЙН ӨВЧНИЙ СУДАЛГАА

Х.Долгорсүрэн, Б.Энхжаргал

ХААИС, Агробиологийн сургууль

e-mail: baljiienkh@yahoo.com

ХУРААНГУЙ

*Манай орны хун амын хүнсний гол таримал бол улаан буудай. Буудай тариалж буй талбай, хураан авч байгаа ургацын хэмжээгээрээ газар тариалангийн үйлдвэрлэлд тэргүүн байрыг эзэлдэг бөгөөд үр тарианы ургамлыг 30 гаруй зүйлийн өвчин өвчлүүлж, ургацыг дунджаар 2.6-10.7 хувиар бууруулж байна. Монгол оронд голлон тариалдаг Халх гол-1, Орхон, Дархан-34, Дархан-74 сортыг сонгон авч үрийн өвчний халдварлалт, голлох *Alternaria*, *Helminthosporium*, *Penicilium*, *Fusarium* өвчнийг илрүүлэн цэвэр өсгөвөр гарган авлаа.*

ТҮЛХҮҮР ҮГС: Фузариоз, үрийн өвчин, буудай, тэжээлт орчин, мөөгөнцөр

ОРШИЛ

Монгол улсын засгийн газраас газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, түүнийг эрчимжүүлэн хүнсний хангамжыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд өвчнөөс шалтгаалан гарч буй буудайн ургацын алдагдлыг бууруулж, үрийн чанарыг дээшлүүлэх ихээхэн анхаарч байна. Иймд манай орны үндсэн таримал зусах буудайн Халх гол -1, Орхон, Дархан-34, Дархан-74 сортуудад үрийн өвчний судлагааг хийх зорилготой бөгөөд энэхүү зорилгыг

биелүүлэхийн тулд дараахь зорилтуудыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

- Халх гол-1, Орхон, Дархан-34, Дархан-74 сортын буудайн үрийн өвчнийг илрүүлэх, халдварыг тогтоох
- Илэрсэн өвчнөөс фузаримын төрлийн мөөгөнцөрийг CLA тэжээлторчинд өсгөвөрлөн цэвэр өсгөвөр гарган тодорхойлох

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ


Бид судалгаандаа эрт болцтой Халх гол-1, дунд болцтой Орхон, Дархан-74, Дархан 34 сортын үрийг ашиглаж судалгааны ажлыг ХААИС-ийн

АБСургуулийн Өвчин судлалын лабораторт хийж гүйцэтгэсэн. Үрийн өвчнийг илрүүлэхийн тулд:

- Удаг цаас ашиглах арга
- Агарт суулгах арга
- *Fusarium*-ийн төрлийн мөөгөнцөрийн цэвэр өсгөвөр ялгахын тулд Лишийн навчит орчинг ашигласан.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН


Судалгаанд ашигласан 4 сортын буудайн үрнээс *Alternaria*, *Helminthosporium*, *Penicillium*, *Fusarium* мөөгөнцөрүүдийг илрүүлсэн.




1-р зураг. Пельтерийн цаасанд ургуулсан үр

Уудаг цаас ашиглан үрийн өвчин илрүүлэх


Уудаг цаас ашиглах аргаар судалгаанд хамрагдсан сортуудаас *Alternaria* өвчний халдвар хамгийн өндөр хувьтай буюу дунджаар 60.4%, *Helminthosporium* 24.9%, *Fusarium* 4.2%, хамгийн бага тархалттай буюу *Penicillium* зөвхөн Халх гол сортын буудайд 2.8% байна.



2-р зураг. Үрийн өвчин илрүүлэлт, Дархан-34, Дархан-74 сорт



3-р зураг. Үрийн өвчин илрүүлэлт, Халх гол, Орхон сорт




4-р зураг. *Alternaria*, *Penicillium*, *Fusarium* өсгөвөр


Агарт суулгах аргаар үрийн өвчин илрүүлэх

Агар тестийн аргаар *Alternaria*, *Helminthosporium*, *Fusarium* төрлийн

мөөгөнцөрийг илрүүлсэн. Үүнээс нийт үрийн 79.3% *Alternaria*, 51.3% *Helminthosporium*, 24.9% *Fusarium*-иар тус тус халдварласан байна.



5-р зураг. Үрийн халдварласан мөөгөнцөр



6-р зураг. PDA тэжээлт орчинд ургуулсан буудайн үрнээс ургасан мөөгөнцөр

***Fusarium*-ийн төрлийн мөөгөнцөрийн цэвэр өсгөвөр ялгаж тодорхойлох**

Fusarium graminearum


PDA тэжээлт орчинд хурдан ургадаг колоний өнгө, ягаан, улаантуяатай өнгөгтэй. CLA тэжээлт

орчинд макроконид сайн үүсдэг. Макроконидын хэлбэр шулуун үзүүр хэсэгрүүгээ нарийссан. 4-6 таславчтай.

Fusarium avenaceum

PDA тэжээлт орчинд хурдан ургадаг колоний өнгө цагаан, ягаавтар өнгөтэй. CLA тэжээлт орчины гадаргууд бүрэг шар өнгийн

макроконидуудын бөөгнөрөл үүсгэнэ. Макроконидын хэлбэр ерөнхийдөө урт нарийхан 3-5 таславчтай.



7-р зураг. Үрнээс ургасан мөөгөнцөрийн колони

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

1967 онд Т.Пунцаг улаан буудайн үрээс *Alternaria*, *Helminthosporium*, *Fusarium*, *Rhizopus*, *Aspergillus*, *Penecillium*, 1979 онд Б.Бямбажав *Alternaria tenuis*, 2006 онд Р.Болормаа *Alternaria*,

Fusarium, *Asfergillus* *Penicillium spp*, 2008 онд Т.Дэжидмаа *Fusarium graminearum*-ийн төрлийн мөөгөнцөрийг илрүүлэн тэмдэглэсэн байдаг.

ДҮГНЭЛТ

1. Уудаг цаас ашиглах аргаар судалгаанд хамрагдсан сортуудад *Alternaria* өвчний халдвар хамгийн өндөр хувьтай буюу дунджаар 60.4%, *Helminthosporium* 24.9%, *Fusarium* 4.2%, хамгийн бага тархалттай буюу *Penicillium* зөвхөн Халх гол сортын буудайд 2.8% тус тус тархалттай байна.
2. Агар тестийн аргаар *Alternaria*, *Helminthosporium*, *Fusarium* төрлийн

мөөгөнцөрийг 4 сортын үрнээс илрүүлсэн. Өвчний халдварлалт 79.3%, 51.3%, 24.9% байна.

3. Фузариумын төрлийн мөөгөнцөрийг CLA тэжээлт орчинд суулган *Fusarium avenaceum*, *Fusarium graminearum*-ийг тус тус тодорхойлсон.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Л. Батмөнх. “Ургамлын аж ахуй” 2013, Улаанбаатар
2. Nancy L., Fisher, L.W., Burgess, T. A., Paul E, Nelson Carnation leaves as a substrate and for preserving cultures of fusarium species

SUMMARY

This work reports the result of survey work on the occurrence of seed-borne diseases of wheat in different parts of Mongolia, on the evaluation of different techniques for the detection of seed-borne fungi present in wheat samples.

- Detection of seed-borne fungi of wheat in blotter test

*A total of four fungal genus *Alternaria*, *Helminthosporium*, *Penicilium* and *Fusarium* were isolated from the seeds of 4 wheat varieties.*

- Seed-borne fungi detected by agar plate test

*Three genera of fungi, including *Alternaria*, *Helminthosporium*, and *Fusarium* were detected by the agar plate test.*